

**ХӨДӨЛМӨР, НИЙГМИЙН ХАМГААЛЛЫН ЯАМНЫ  
2023 ОНЫ 03 ДУГААР САРЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЙЛАН**

2023 оны 03 дугаар сарын 31-ний өдөр

№	Хийсэн ажил /чиглэлээр/	Гүйцэтгэсэн ажлын төрөл дараахь 4-н аль нэгийг сонгож (√) тэмдэглэгээ хийх			
		Тулгамд- сан ажил	УИХ, ЗГ-т өргөн барьсан	Салбарын хүрээнд хийгдсэн	Шинэлэг ажил
<b>I</b>	<b>Хууль эрх зүйн орчинг боловсронгуй болгох чиглэлээр</b>				
1.	“Ажиллах хүчний шилжилт хөдөлгөөний тухай хууль”-ийн 32 дугаар зүйлийн 32.8-д “Гадаад ажилтны ажлын байрны төлбөр төлөх, хөнгөлөх, чөлөөлөх, төлбөрийн зөрүүг буцаан олгох, тэдгээрийн бүртгэлийг хөтлөхтэй холбоотой журмыг Засгийн газар батална” гэж заасны дагуу журмын төслийг хуулийн нэмэлт, өөрчлөлттэй уялдуулан боловсруулж холбогдох журмын дагуу 2023 оны 3 дугаар сарын 15-ны өдрийн Засгийн газрын ээлжит хуралдаанаар хэлэлцүүлэн батлуулав.		√		
2.	“Ажиллах хүчний шилжилт хөдөлгөөний тухай хууль”-ийн 32 дугаар зүйлийн 32.4-т заасныг үндэслэн Засгийн газрын “Ажлын байрны төлбөрөөс чөлөөлөх тухай” 2023 оны 90 дүгээр тогтоолыг батлууллаа. Тус тогтоолоор Монгол Улсын Засгийн газар болон Бүгд Найрамдах Энэтхэг Улсын Экспорт-Импортын банк хоорондын “Зээлийн ерөнхий хэлэлцээр”-ийн хүрээнд Дорноговь аймгийн Алтанширээ сумын нутаг дэвсгэрт барих газрын тос боловсруулах үйлдвэрийн анхдагч процессын болон дагалдах байгууламжийн ажил (ЕРС-2), цахилгаан станцын ажил (ЕРС-3) гүйцэтгэх “Эм И Ай Эл интернэшнл” ХХК-ийн 400, газрын тос дамжуулах хоолойн ажил гүйцэтгэх “Норинко Интернэйшнл Кооперэйшн” ХХК-ийн 480 гадаад ажилтныг 2023 онд ажлын байрны төлбөрөөс чөлөөлсөн.		√		
3.	Хөдөлмөрийн тухай хуулийн 28.1, 28.5 дахь хэсэгт заасны дагуу “Ажил хаях, ажлын байр түр хаах /локаут/-ыг хориглох хүн амд нэн шаардлагатай үйлчилгээ үзүүлдэг аж ахуйн нэгж, байгууллагын жагсаалт” батлах тухай Засгийн газрын тогтоолын төсөл, Ажил хаях, ажлын байр түр хаах /локаут/ үед хүн амд үзүүлэх наад захын үйлчилгээний хэмжээг батлах тухай Засгийн газрын тогтоолын төслийг тус тус боловсруулж, яамдын саналыг тусгав. Засгийн газрын тогтоолын төслүүдийг Хөдөлмөр, нийгмийн түншлэлийн гурван талт Үндэсний хорооны хурлаар хэлэлцүүлэн, ЗГХЭГ-т хүргүүлэхээр төлөвлөн ажиллаж байна.			√	
4.	Цахим хөгжил, харилцаа холбооны яамтай хамтран төрийн үйлчилгээний албан тушаалын ангилалд хамаарч ажиллах мэдээллийн технологийн чиглэлээр мэргэшсэн, өндөр ур чадвар бүхий ажилтны цалингийн хэмжээ тогтоох итгэлцүүр батлах Засгийн газрын тогтоолын төсөл боловсруулав.			√	
5.	Нийгмийн даатгалын ерөнхий хуулийн, Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэврийн тухай хуулийн, Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэмжийн тухай, Нийгмийн даатгалын сангаас олгох үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний тэтгэвэр, тэтгэмж, төлбөрийн тухай, Хувийн нэмэлт тэтгэврийн тухай хуулийн төслүүдийг ахмадуудын төлөөллөөр 3 дугаар сарын 9-ний өдөр, ажил олгогчдын төлөөллөөр 3 дугаар сарын 10-ны өдөр тус тус хэлэлцүүлсэн. Мөн худалдааны танхим болон танхимын гишүүн байгууллагуудаар хуулийн төслийг 3 дугаар сарын 29-ний өдөр хэлэлцүүлээд байна.			√	
6.	Нийгмийн даатгалын багц хуулийн төслийг УИХ-ын чуулганаар хэлэлцүүлэхтэй холбогдуулан хуулийн төслийг танилцуулах, хэлэлцүүлэх, иргэд олон нийтээс санал авах уулзалтыг Булган аймаг, Орхон аймаг, Дархан-Уул аймагт 2023 оны 03 сарын 09, 10-ны өдрүүдэд, Дундговь, Говьсүмбэр аймагт 2023 оны 03 дугаар сарын 22, 23-ны өдрүүдэд, Дорноговь аймагт 2023 оны 03 дугаар сарын 31-ний өдөр тус тус зохион байгууллаа.			√	
7.	Нийгмийн бодлогын байнгын хорооны зөвлөхүүдтэй Нийгмийн даатгалын багц 5 хуулийн төслийг танилцуулах, хэлэлцүүлэх, уулзалтыг 2 удаа хамтран зохион байгуулав.		√		

8.	Нийгмийн даатгалын багц хуулийн төслийг УИХ-ын нэгдсэн чуулган болон НББХ-ны хэлэлцүүлэгт бэлтгэх, санал дүгнэлт боловсруулах чиг үүрэг бүхий ажлын хэсгийн анхны хуралдааныг 3 дугаар сарын 28-ны өдөр зохион байгуулж, багц хуулийн төслийг танилцуулж, холбогдох материал, гарын авлага хэвлэж бэлтгэн ажлын хэсэгт хүргүүлсэн.		√		
9.	Дэлхийн Банкны Төсөв, санхүүгийн тогтвортой байдлыг бэхжүүлэх төслийн хүрээнд Олон давхаргат тэтгэврийн тогтолцоонд шилжихэд тэтгэврийн параметрийн өөрчлөлт, Нийгмийн даатгалын шинэчлэлтэй холбоотой тэтгэврийн даатгалын сангийн актуар тооцооллыг олон улсын зөвлөлтэй хамтран боловсруулж, тайланг эцэслэсэн байна. Мөн энэхүү тайланг хэлэлцүүлэх арга хэмжээг салбарын холбогдох ажилтнуудыг оролцуулан 2023 оны 03 дугаар сарын 20, 21-ний өдрүүдэд зохион байгууллаа.			√	
10.	Нийгмийн халамжийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийг боловсруулан 2021 онд Засгийн газарт хүргүүлж байсан бөгөөд цаг хугацааны хувьд дахин сайжруулах, тоон мэдээллийг шинэчлэх хэрэгцээ, шаардлагын дагуу ажлын хэсэг Нийгмийн халамжийн тухай хуулийн төсөл, Хүүхэд, гэр бүлд тэтгэмж олгох, олон хүүхэдтэй эхийг урамшуулах тухай хуулийн төслүүд болон дагалдах хуулийн төслүүд дээр ажиллав.			√	
11.	Нийгмийн бодлогын байнгын хорооны 3 дугаар сарын 29-ний өдрийн Төрөөс олгох урамшууллаас нийгмийн даатгалын болон эрүүл мэндийн даатгалын шимтгэл суутган төлөх тухай хуулийн төслийг хэлэлцүүлэгт бэлтгэх үүрэг бүхий ажлын дэд хэсгийн хуралдаанд холбогдох мэдээ, мэдээллийг бэлтгэн хүргүүлэв.		√		
12.	Хүүхдийн хөгжлийг дэмжих үйлчилгээний хууль эрх зүйн орчныг боловсронгуй болгох зорилт, “Хилийн чанад дахь Монголчуудын нэгдсэн чуулга уулзалт”-ын мөрөөр хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөөний хэрэгжилтийн хүрээнд Хүүхдийн зуслангийн үйл ажиллагаа Ерөнхий шаардлага MNS 5633:2019 стандартыг шинэчлэн боловсруулах хүрээнд Соёлын яам, Монголын үндэсний зуслангийн холбоо, Хилийн чанад дахь Монголчуудын зөвлөл болон холбогдох төрийн бус байгууллагын төлөөлөл оролцсон хэлэлцүүлэг зохион байгууллаа. Хэлэлцүүлгээр хөдөлмөр зуслан, нүүдэлчин зуслан байгуулах хэрэгцээ, шаардлага, стандартад оруулах өөрчлөлтийг хэлэлцэж, санал солилцлоо.			√	
13.	Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хуулийн 32 дугаар зүйлийн 32.3 дахь хэсэг, Хүүхэд хамгааллын тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.5 дахь хэсэгт заасан “Нөхцөл байдлын үнэлгээ хийх” журмын төслийг эцэслэж ХЗДХЯ-нд хүргүүлсэн. Батлуулахад бэлтгэж байна.			√	
14.	“Хяналт шалгалтад хяналтын хуудас хэрэглэх журам”-ын төсөл боловсруулж хавсралтаар салбарын хяналт шалгалтанд ашиглах хяналтын хуудасны загварын төслийг тус тус боловсруулан дэд сайдын 2023 оны 03 дугаар сарын 17-ны өдрийн А/28 дугаар тушаалаар батлуулсан. <b>1. Хөдөлмөрийн хяналтын чиглэлээр:</b> 4.1.2 кодтой Хөдөлмөрийн аюулгүй байдлыг шалгах хяналтын хуудас, 4.6 кодтой Хөдөлмөрийн харилцааг шалгах хяналтын хуудас <b>2. Хөдөлмөрийн эрүүл ахуйн хяналтын чиглэлээр:</b> 4.1.1 кодтой Хөдөлмөрийн эрүүл ахуйг шалгах хяналтын хуудас, <b>3. Нийгмийн хамгааллын хяналтын чиглэлээр:</b> 4.2 кодтой Ажилтны нийгмийн хамгааллыг шалгах хяналтын хуудас, 4.3 кодтой Нийгмийн даатгалын сангийн үйл ажиллагааг шалгах хяналтын хуудас, 4.4 кодтой Хөдөлмөрийн чадвар алдалтын хувь тогтоолтыг шалгах хяналтын хуудас, 4.5 кодтой Нийгмийн халамжийн сангийн үйл ажиллагааг шалгах хяналтын хуудас, 4.7 кодтой Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангийн үйл ажиллагааг шалгах хяналтын хуудас			√	
15.	Улсын (ахлах) байцаагчдын хөдөлмөрийн жишиг норм, норматив, “Үйлдвэрлэлийн зориулалттай машин механизм, тоног төхөөрөмжид гэрчилгээ олгох хүсэлтийг цахимаар хүлээн авах, хянах, гэрчилгээ олгох журам”-ыг дэд сайдын 2023 оны 03 дугаар сарын 17-ны өдрийн А/26 дугаар тушаалаар батлав.			√	
16.	Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 185 дугаар зүйлийн 2 дахь хэсэг, Төрийн хяналт шалгалтын тухай хуулийн 5 <sup>5</sup> дугаар зүйлийн 5 <sup>5</sup> .3 дахь хэсэгт заасны дагуу “Эрсдэлийн ангилалд хамаарах объектын жагсаалт, шалгалтад хамруулах давтамжийн хугацаа”-г дэд сайдын 2023 оны 03 дугаар сарын 22-ны өдрийн А/31 дүгээр тушаалаар батлуулсан.			√	

17.	Эрсдэлийн шалгуур үзүүлэлт батлах тухай Засгийн газрын тогтоолын төсөлд санал авахаар яамд руу албан бичиг хүргүүлсэн.			√	
18.	Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуульд заасан хэргийн харьяалалд өөрчлөлт оруулах, түүнчлэн зөрчлийн хэрэг бүртгэлтийн ажиллагаа явуулах, харьяаллын давхардлыг арилгах талаар яаралтай арга хэмжээ авах тухай Төрийн нарийн бичгийн даргын 2023 оны 03 дугаар сарын 10-ны өдрийн 03/624 тоот албан бичгийг Хууль зүй, дотоод хэргийн яаманд хүргүүлсэн.			√	
19.	Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуулийн 1.8-д заасан зөрчлийн хэрэг бүртгэлтийн ажиллагааны харьяаллын асуудлаар Улсын ерөнхий прокурорт, Зөрчлийн тухай хуулийн 10.52 дугаар зүйлд өөрчлөлт оруулах асуудлаар Хууль зүй, дотоод хэргийн яаманд тус тус албан бичиг хүргүүлсэн.			√	
20.	-Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөлд орсон өөрчлөлттэй холбоотой үзэл баримтлалын төсөл, хуулийн хэрэгцээ шаардлагын тандан судалгааны төслүүдийг сайжруулан ажиллаж байна. Хуулийн төслийг Хууль, эрх зүйн хэлтэс болон Хүний эрхийн үндэсний комисст хүргүүлэн санал авч байна. -Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн эрхийн тухай конвенц, Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хууль нь дотоодын хууль тогтоомжтой хэрхэн нийцэж байгаа талаарх судалгаа хийх, тайлан, зөвлөмж боловсруулах зөвлөх үйлчилгээний ажлын даалгавар, үйл ажиллагааны нарийвчилсан төлөвлөгөөний төслийг боловсруулан НҮБ-ын БСШУ-ны Монгол дахь салбарт хүргүүлэв.			√	
21.	-Саадгүй байдал, хүртээмжийн тухай анхдагч хуулийн төслийг үзэл баримтлалын төсөл болон холбогдох баримт бичгийн хамт Хууль зүй дотоод хэргийн яаманд хүргүүлэхээр ажиллаж байна. Энэ хүрээнд хуулийн төсөлд ТББ-уудаас ирүүлсэн саналыг тусган хуулийн төслийг боловсруулсан бөгөөд дагалдан гарах хуулийн төслүүдийг боловсруулж байна. Хуулийн төслийг Хууль, эрх зүйн хэлтэс болон Хүний эрхийн үндэсний комисст хүргүүлэн санал авч байна.			√	
22.	-Олон Улсын хөдөлмөрийн байгууллагатай хамтран Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хуулийг шинэчлэн боловсруулах ажлын төлөвлөгөө гаргав. -Олон Улсын хөдөлмөрийн байгууллагатай хамтран Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйг дэмжих суурь тогтолцооны 187 дугаар конвенцид нэгдэх асуулаарх дотоодын хууль тогтоомжид нийцлийн судалгааг хийх ажлын төлөвлөгөөг боловсруулаад байна.			√	
<b>II Бодлого төлөвлөлтийг сайжруулах чиглэлээр</b>					
23.	Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангийн 2024 оны дунд хугацааны төсвийн хүрээний мэдэгдэлд тусгах саналыг боловсруулан холбогдох газарт хүргүүллээ.			√	
24.	Хөдөлмөр эрхлэлтийн үндэсний зөвлөлийн 2023 оны 2 дугаар сарын 03-ны өдрийн хуралдааны 04 дүгээр тогтоолоор баталсан “Эрэлтэд нийцсэн ур чадвар”-ын хөтөлбөрийг хэрэгжүүлэх үйл ажиллагааны удирдамж боловсруулах уулзалтыг 2023 оны 3 дугаар сарын 07, 23-ны өдрүүдэд танхимаар болон цахимаар ЗГХА-Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний ерөнхий газар, Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сургалт, үнэлгээ, судалгааны институт, аймаг, дүүргийн Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газар, хэлтсийн дарга нарыг оролцуулан удирдамжийн төслийг боловсрууллаа. Энэ хүрээнд “Эрэлтэд нийцсэн ур чадвар олгох” хөтөлбөрийн хүрээнд богино хугацааны сургалтын чиглэлийг тодорхойлох зорилгоор Монгол Улсын Их Хурлын 106 дугаар тогтоолоор баталсан “Шинэ сэргэлтийн бодлого”-ын хүрээнд богино хугацааны сургалтын байгууллагаар бэлтгэх боломжтой эрэлттэй ажлын байр, шаардлагатай ажиллах хүчин, ур чадварын хэрэгцээний талаарх судалгаа, мэдээллийг авах тухай санал боловсруулж, чиг үүргийн 7 яаманд 2023 оны 3 дугаар сарын 13-ны өдрийн 03/633 тоот албан бичгээр хүргүүллээ.			√	
25.	Засгийн газрын 2021 оны “Залуучуудыг хөдөлмөрт бэлтгэх” тогтоолд нэмэлт, өөрчлөлт оруулан шинэчлэн боловсруулж, бүх яамдаас тус тогтоолын төсөлд санал авахаар 2023 оны 3 дугаар сарын 21-ний өдрийн 02/733 тоот албан бичгээр хүргүүллээ.			√	
26.	Монгол Улсын Ерөнхий сайдын ивээл дор 2023 оны 3 дугаар сарын 21-ний өдөр зохион байгуулагдсан “Эерэг Монгол” чуулганд “Хөдөлмөр эрхлэлт, ажлын байранд суурилсан сургалтын хэрэгцээ, шаардлага” сэдвийн хүрээнд Монгол Улсын засгийн газар, Боловсрол, шинжлэх ухааны			√	

	ям, JCI, Отгонтэнгэр их сургууль хамтран зохион байгууллаа. Тус чуулганд Хөдөлмөр, нийгмийн хамгааллын дэд сайд үндсэн илтгэл тавьж, панелистаар оролцов.				
27.	-“Алсын хараа-2050” Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлогын “Цахим Монгол” зорилтын хүрээнд хөдөлмөр, нийгмийн хамгааллын салбарыг бүхэлд нь цахимжуулах, иргэн бүрт төрийн үйлчилгээг ил тод, нээлттэй, түргэн шуурхай, чирэгдэлгүй, хүртээмжтэй хүргэх тогтолцоог бүрдүүлэх зорилгоор Дэлхийн банкны “Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих төсөл”-ийн санхүүжилтээр Монгол Улсын Хөдөлмөр эрхлэлтийн цахим систем “Ejob” платформыг 2022 онд ашиглалтад оруулсан. -“Ejob” платформын үйл явцын талаарх тайлан, мэдээг 10 хоног тутам авч нэгтгэн, үр дүнг Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдад танилцуулж байна. 2023 оны 3 сарын байдлаар “Ejob” платформд Бүртгэлтэй ажлын байрны тоо-9318, Ажил хайгчийн тоо-20196, Ажил олгогчийн тоо-4841, Ажилд зуучлагдсан иргэдийн тоо-2355 болсон байна.			√	
28.	Хөдөлмөрийн тухай хуулийн 147.3 дахь хэсэгт заасны дагуу “Хөдөлмөрийн сонирхлын маргааныг хөдөлмөрийн зуучлагчийн дэмжлэгтэйгээр зохицуулах журам”-ыг Засгийн газрын 2023 оны 04 дүгээр тогтоолоор, “Хөдөлмөрийн арбитрын дүрэм”-ийг 05 дугаар тогтоолоор, Хөдөлмөр, нийгмийн түншлэлийн гурван талт Үндэсний хорооны 2023 оны 03 дугаар тогтоолоор “Хөдөлмөрийн зуучлагчийн ёс зүйн дүрэм”, “Хөдөлмөрийн арбитрчийн ёс зүйн дүрэм”-ийг тус тус баталсныг аймаг, нийслэлийн ХХҮГ, аймгуудын Хөдөлмөр, нийгмийн түншлэлийн 3 талт хороодод хүргүүлэв. Тус журам, дүрмийн дагуу хөдөлмөрийн зуучлагч, хөдөлмөрийн арбитрчдын нэрсийн жагсаалтыг батлахаар нэрс ирүүлэх бичгийг 2023 оны 03 дугаар сарын 15 03/669, 03/670 албан бичгээр хүргүүлэв.			√	
29.	Сингапур улсын төрийн албаны цалин хөлсний тогтолцоог судалж холбогдох арга хэмжээг авах арга хэмжээний хүрээнд Монгол Улсын төрийн албаны цалин хөлсний тогтолцооны өнөөгийн нөхцөл байдал, тулгамдаж буй асуудлыг танилцуулах уулзалтын бэлтгэл ажлыг ханган, уулзалт зохион байгуулав.			√	
30.	Эрүүл мэндийн сайдын 2023 оны А/77 дугаар тушаалаар байгуулагдсан “Эрүүл мэндийн салбарын цалин хөлс, ажилтны ажлын гүйцэтгэл, бүтээмжийн урамшууллын өнөөгийн байдалд судалгаа хийх, боловсронгуй болгох санал, дүгнэлт гаргах” ажлын хэсгийн үйл ажиллагааны хүрээнд эрүүл мэндийн салбарын холбогдох албан тушаалтнуудтай 2 удаагийн уулзалт зохион байгууллаа. Холбогдох баримт бичгүүдэд дүн шинжилгээ хийж, зөвлөмжийн төсөл боловсруулав.			√	
31.	Хүний эрхийн комиссоос зохион байгуулсан “Төрийн үйлчилгээний албан хаагчдын хөдөлмөрлөх эрхийн хэрэгжилт” сэдэвт хэлэлцүүлэгт оролцож төрийн албан хаагчдын цалин хөлсний талаарх өнөөгийн байдал, тулгамдаж буй асуудал, цаашид хэрэгжүүлэхээр төлөвлөж буй үйл ажиллагааны талаар танилцуулга хийв.			√	
32.	Хөдөлмөр, нийгмийн зөвшлийн гурван талт 2021-2022 оны Улсын хэлэлцээрийн хэрэгжилтийн тайланг яамд, Монголын үйлдвэрчний эвлэлийн холбоо, Монголын ажил олгогч эздийн нэгдсэн холбоо болон холбогдох бусад байгууллагуудаас авч нэгтгэн, хэлэлцээрийн хэрэгжилтийн байдалд заалт бүрээр гурван талт ажлын хэсгээс дүгнэхэд биелэлт 87 хувьтай байна. МАОЭНХ болон МҮЭХ-нд 2021-2022 оны Улсын хэлэлцээрийн тайлангийн биелэлт, нэгдсэн дүнг албан тоотын хамт хүргүүлэв.			√	
33.	Азийн хөгжлийн банкны санхүүжилтээр “Нийгмийн хамгааллын санхүүжилт” техник туслалцааны төсөл хэрэгжиж эхэлсэн бөгөөд энэ хүрээнд холбогдох мэдээ, мэдээллийг хүргүүлж, 3 дугаар сарын 14, 15-ны өдрүүдэд уулзалт, хэлэлцүүлэг хийж, хамтран ажиллаж байна.				
34.	Монгол Улсын хөгжлийн 2024 оны төлөвлөгөөний төсөлд тусгах Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын эрхлэх асуудлын хүрээнд хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээний санал, Хөдөлмөр, нийгмийн хамгааллын салбарын танилцуулга зэрэг холбогдох мэдээллийг Монгол Улсыг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл, Монгол Улсын 2021-2025 оны хөрөнгө оруулалтын хөтөлбөр, Монгол Улсын Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө зэрэг бодлогын баримт бичгийг үндэслэн Эдийн засаг хөгжлийн сайдын 2022 оны А/167 дугаар тушаалаар батлагдсан “Улсын хөгжлийн төлөвлөгөө боловсруулах аргачлал”-ын дагуу боловсруулан Эдийн засаг, хөгжлийн яаманд цахимаар болон 2023 оны 03 дугаар сарын 06-ны өдрийн 02/596 тоот албан бичгээр хүргүүлээд байна.			√	

35.	“Төгсөлтийн аргачлал туршилтын хөтөлбөр”-г хамрагдахаар сонгогдсон 1520 өрх /мөн хяналтын 1514 өрх/-ийн тоо, мэдээллийг дүүрэг тус бүрээр гарган СХД, ЧД, БЗД-ийн ЗДТГ болон Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний хэлтэст 2023 оны 3 дугаар сарын 15-ны өдрийн 03/673 дугаар албан бичгээр хүргүүлсэн. Түүнчлэн, уг туршилтын хөтөлбөрийн хүрээнд баримтлах “төгсөлтийн шалгуур үзүүлэлтүүд”-ийг эцэслэн боловсруулж, батлуулав. АйАрЭм судалгааны байгууллагын гүйцэтгэж байгаа зах зээлийн судалгааны хүрээнд уг хөтөлбөрт хамрагдагчдын эрхлэх боломжтой аж ахуй эрхлэлтийн урт болон богино жагсаалтыг тодорхойлсныг эцэслэх зорилгоор санал солилцох уулзалтуудыг зохион байгуулав.			√	
36.	“Цар тахлын үед хариу арга хэмжээ авах нийгмийн хамгааллын төсөл 2”-ын хэрэгжилтэд дунд хугацааны үнэлгээ хийх АХБ-ны Зүүн Азийн Бүсийн газрын нийгмийн хамгааллын Тэргүүлэх мэргэжилтэн, Төслийн багийн ахлагч Карин Шельцих 2023 оны 02 дугаар сарын 27-ны өдрөөс 03 дугаар сарын 03-ны өдрүүдэд Монгол Улсад ажилласан. Энэ хүрээнд Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамнаас нийслэлийн 3 дүүрэгт хэрэгжүүлж буй Төгсөлтийн аргачлал туршилтын хөтөлбөрийн хэрэгжилтийн явц, халамжийн системийн цахимжуулалт болон халамжийн үйлчилгээг сайжруулах чиглэлээр хэрэгжүүлж буй ажлуудын талаар танилцуулж ажиллав. Мөн ажиллах хугацаанд Сангийн яамны Хөгжлийн санхүүжилт, хөрөнгө оруулалтын газар, нийслэлийн ЗДТГ, СХД, ЧД, БЗД-ийн ЗДТГ, Монголын улаан загалмай нийгэмлэг, АйАрЭм судалгааны байгууллага болон төслийн хүрээнд ажиллаж байгаа зөвлөхүүдийн ажлын явцтай танилцах уулзалтуудыг зохион байгуулж, цаашид ажлын уялдааг хангаж, хамтран ажиллах талаар харилцан санал солилцлоо.			√	
37.	“Орлогыг орлуулан тооцох хосолмол аргачлал”-аар нийгмийн халамжийн дэмжлэг, тусалцаа зайлшгүй шаардлагатай өрхийн мэдээллийг шинэчлэх, мэдээлэл цуглуулах ажлыг зохион байгуулах, судалгааны удирдамжийн төслийг боловсруулав.			√	
38.	Хүүхдийн мөнгөтэй холбоотой иргэд, ТББ-аас ирүүлсэн шаардлагын хариуг бэлтгэн 2023 оны 03 дугаар сарын 15-ны өдрийн 02/677, 02/678 дугаар албан бичгээр хүргүүлэв. Мөн иргэдийн төлөөллөөс ирүүлсэн шаардлагад хариу тайлбар ирүүлэх тухай ЗГХЭГ-аас ирсэн албан бичигт Хүүхдийн мөнгөн тэтгэмжийн талаарх тоо, мэдээллийг бэлтгэн 2023 оны 03 дугаар сарын 14-ний өдрийн 02/66 дугаар албан бичгээр хүргүүлэв. Хүүхдийн мөнгөн тэтгэмжтэй холбоотой өргөдөл өгсөн иргэдийн мэдээллийг шалгаад зөрүүтэй мэдээллээ залруулсан 21 иргэний, мэдээлэл засуулаад хамрагдахгүй хэвээр байгаа 43 иргэний өргөдөлд хариу бэлтгэн 1111 төвөөр дамжуулан иргэдэд хариу өгөв. Хүүхдийн мөнгөн тэтгэмжийг батлагдсан төсөвт багтаан бүх хүүхдэд олгох УИХ-ын тогтоолын төсөл, танилцуулга, төсвийн саналын хувилбарууд боловсруулсан.			√	
39.	2024 оны Төсвийн хүрээний мэдэгдэлд нийгмийн халамжийн зарим хөтөлбөр, арга хэмжээний зардлыг нэмэгдүүлэхээр санал бэлтгэж тусгуулав. <ul style="list-style-type: none"> <li>○ Нийгмийн халамжийн тэтгэврийн хэмжээг 8.3%</li> <li>○ Асаргааны тэтгэмжийн хэмжээ 84500 төгрөгийг 150000 төгрөгт хүргэх /зөрүүг арилгах/</li> <li>○ Байнгын асаргаа шаардлагатай хөгжлийн бэрхшээлтэй хүүхдээ асарч байгаа эцэг, эхэд олгох асаргааны тэтгэмж 123100 төгрөгийг 150000 мянган төгрөгт хүргэх</li> <li>○ Байнгын асаргаа шаардлагатай хөгжлийн бэрхшээлтэй ахмад настан, хөгжлийн бэрхшээлтэй иргэнд олгох амьжиргааг дэмжих мөнгөн тэтгэмж 60000 төгрөгийг 90000 төгрөгт хүргэх /улиралд нэг удаа олгож байгаа, 2012 оноос хойш нэмээгүй/</li> <li>○ Хүнсний эрхийн бичгийн мөнгөн дүнг 2 дахин нэмэгдүүлэхээр нийт 102 тэрбум төгрөг халамжийн санд нэмж тусгуулахаар төсвийн тооцоолол, саналыг бэлтгэлээ.</li> </ul>			√	
40.	Парисын хэлэлцээрийн хүрээнд баталсан “Үндэсний Тодорхойлсон Хувь Нэмрийг 2021-2025 онд хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөний 2022 оны хэрэгжилтийн тайланг 2023 оны 03 дугаар сарын 13-ны өдрийн 05/638 тоот албан бичгээр Байгаль орчин, аялал жуулчлалын яаманд хүргүүлсэн.	√			
41.	Нийгмийн халамж болон нийгмийн даатгалын дунд болон урт хугацааны үр нөлөөг төлөвлөх динамик загвар боловсруулах, сургалт явуулах, зөвлөх үйлчилгээ үзүүлэх Системийн динамик ТББ-тай гэрээ байгуулсаны дагуу ажлын төлөвлөгөөг баталж, сургалтыг 2023 оны 3 сараас эхлэн явуулж байна. Сургалтад оролцох ажилтан албан хаагчдын нэрсийг ХНХЯ-ны холбогдох газар,			√	

	хэлтэс, харьяа агентлагууд судалгааны институтээс авч, сургалтыг амжилттай зохион байгуулж байна.				
42.	Дэлхийн банкнаас аналитик хэрэгслүүдийн хүрээнд төсвийн бодлогын шинэчлэлийг загварчлахад ядуурал, тэгш бус байдалд хэрхэн нөлөөлж болох түүнчлэн өгөгдлийн шаардлагуудын талаар, уг аргачлалыг хүнсний талонд хэрхэн ашиглаж болох тухай сургалтыг 2023 оны 03 дугаар сарын 30-ны өдөр зохион байгуулахаар бэлтгэн ажиллаж байна.			√	
43.	“Хөдөөгийн охид, эмэгтэйчүүдийн жендэрийн тэгш байдлыг хангах, чадавхижуулах чиглэлээр гаргасан ололт амжилт, тулгарсан бэрхшээл” сэдэвт НҮБ-ын UNW/2022/007 тоот тогтоолын хэрэгжилтийн тайланг боловсруулж, орчуулгад шилжүүлсэн.			√	
44.	АНУ-ын Нью-Йорк хотноо энэ оны 3 дугаар сарын 6-17-ны өдрүүдэд зохион байгуулагдах НҮБ-ын Эмэгтэйчүүдийн аж байдлын комиссын 67 дугаар чуулганы үндсэн илтгэлийг боловсруулав.			√	
45.	Хөдөлмөр, нийгмийн хамгааллын жендэрийн салбар зөвлөлийн 2023 оны төлөвлөгөөг тус яамны Төрийн нарийн бичгийн даргаар батлуулж, харьяа салбар зөвлөлд хүргүүлэв.			√	
46.	ЗГХЭГ-аас санаачлан хийж байгаа Тогтвортой хөгжил 2050-н хэрэгжилтийн тайланд ХҮНИЙ ХӨГЖИЛ бүлгийн хүрээнд Боловсрол, Эрүүл мэнд, Гэр бүл, Шинжлэх ухаан, Инновац, Хүнд ээлтэй амьдрах орчин, Хөдөлмөрийн зах зээл, Монгол хүний удмын сангийн мэдээллийг тус тус нэгтгэн боловсруулав.			√	
47.	Хүүхдийн эрх, хамгааллын захиргааны нэгтгэл маягтыг эцэслэж ҮСХ-оор батлуулахад бэлэн болгосон. Мөн Монгол Улс дахь гэр оронгүй иргэдийн нөхцөл байдал сэдэвт танилцуулга бэлтгэсэн. Тэтгэврийн даатгалын сангийн алдагдал, нөлөөлсөн хүчин зүйлс Постер, Хөдөлмөрийн хэвийн бус нөхцөл Постер, МУ-ын олон давхаргат тэтгэврийн тогтолцоо Постерыг тус тус бэлтгэв.			√	
48.	Залуучуудын хөгжлийг дэмжих тухай хуулийн хэрэгжилтийн үнэлгээг гүйцэтгэх зөвлөх үйлчилгээний ажлын удирдамжийг батлуулж, зөвлөх үйлчилгээний урилгыг өдөр тутмын хэвлэл мэдээллийн хэрэгслээр ажлын 7-оос доошгүй өдрийн хугацаанд нэвтрүүлж байна. Зөвлөх үйлчилгээний саналыг 4 дүгээр сарын 05-ны өдрийг хүртэлх хугацаанд хүлээж авна.	√			
49.	Аймгийн Залуучуудын хөгжлийн төв /ЗХТ/-ийн дэргэд цахим мэдээлэл, сургалтын “Юнител Хаб” цэг байгуулах талаар “Юнител” групптэй ХОСБ байгуулах хүрээнд холбогдох тушаал шийдвэр буюу Санамж бичиг байгуулах тухай зөвшөөрлийг ХНХЯ-ны Төрийн нарийн бичгийн даргын 2023 оны 03 дугаар сарын 29-ний өдрийн А/86 дугаар тушаалаар баталсан. Санамж бичгийг 04 дүгээр сард байгуулах юм.	√			
50.	Нийгмийн ажилтны мэргэжлийн ёс зүйн салбар хороог 21 аймаг, нийслэл, 9 дүүрэгт салбар байгуулж, үйл ажиллагааны журам баталж, гишүүдийг бүртгэлжүүлсэн. 2023 оны 4 дүгээр сард Нийгмийн ажилтны ёс зүйн салбар хорооны гишүүдийг чадавхижуулах сургалт зохион байгуулахаар бэлтгэж байна.			√	
51.	Гэр бүл, хүүхэд, залуучуудын салбарт ажиллаж байгаа нийгмийн ажилтнуудын албан тушаалын тодорхойлолтыг шинэчлэн батлуулах зорилгоор ажлын байрны шинжилгээний үнэлгээнд дүн шинжилгээ хийв.			√	
52.	Нью-Йорк хотноо энэ оны 3 дугаар сарын 6-17-ны өдрүүдэд болох НҮБ-ын Эмэгтэйчүүдийн аж байдлын комисс 67 дугаар чуулганд оролцох бэлтгэл ажлын хүрээнд дараах бичиг баримтыг бэлтгэв. Үүнд: -НҮБ-ын Эмэгтэйчүүдийн аж байдлын комисс UNW/2022/007 тоот тогтоолын хэрэгжилтийн тайлан; -“Хөдөөгийн охид, эмэгтэйчүүдийн жендэрийн тэгш байдлыг хангах, чадавхижуулах чиглэлээр гаргасан ололт амжилт, тулгарсан бэрхшээл” сэдвээр үндэсний сайн дурын илтгэл; -“Жендэрийн тэгш байдлыг хангах, эмэгтэйчүүд, охидыг чадавхижуулахад дижитал эрин үеийн инноваци, технологийн өөрчлөлт болон боловсрол” сэдвээр ерөнхий хуралдаанд хэлэх үг; -Тэргүүлэх сэдвийн асуудлаарх Сайд нарын түвшний дугуй ширээний уулзалтад Монголын төлөөлөгчийн хэлэх үгийн төсөл болон бусад шаардлагатай мэдээллийг тус тус бэлтгэв.			√	
53.	НҮБ, ХАС-тай хамтран хэрэгжүүлж буй “Жендэрт суурилсан хүчирхийлэлтэй тэмцэх нь” төслийн хүрээнд нийслэлийн Чингэлтэй дүүрэгт Эрэгтэйчүүдэд нийгэм сэтгэл зүйн зөвөлгөө өгөх төвийг байгуулахтай холбоотой эрэгтэйчүүдийн чиглэлээр хийсэн судалгаа шинжилгээний тайланг				√

	сонсох, боловсруулсан арга зүйн үр дүнг хэлэлцэх төр, төрийн бус байгууллагын 40 гаруй төлөөлөл оролцсон уулзалтыг зохион байгууллаа.				
54.	Сэлэнгэ аймгийн Хүүхдийн төлөө зөвлөлийн өргөтгөсөн хуралдаанд “Хүүхэд хамгааллын чиглэлээрх төрөөс баримталж буй бодлого, Хүүхдийн төлөө зөвлөлийн ажиллах чиг үүрэг, цаашид анхаарах асуудал” сэдвээр мэдээлэл хийж оролцов. Уг хуралд 17 сум 6 тосгоны Засаг дарга, захирагч, нийгмийн бодлогын асуудал хариуцсан мэргэжилтэн оролцов.			√	
55.	Төрөлжсөн асрамжийн үйлчилгээнд хамрагдаж байгаа хүүхдийн зардлын нормативыг шинэчлэн боловсруулж, халамж, асрамжийн төвүүдийн саналыг тусган, эцэслэв.			√	
56.	Мэргэжлийн хяналтын байгууллагын чиг үүрэг салбарын яаманд шилжин ирсэнтэй холбогдуулан хөдөлмөр, хөдөлмөрийн эрүүл ахуй, нийгмийн хамгааллын хяналтын улсын (ахлах) байцаагчдын үндсэн чиг үүргийг тодорхойлох зорилгоор албан тушаалын тодорхойлолт боловсруулах ажлын хэсэг байгуулагдсан. Ажлын хэсэг хөдөлмөр, хөдөлмөрийн эрүүл ахуй, нийгмийн хамгааллын хяналтын улсын (ахлах) байцаагчдын албан тушаалын тодорхойлолт, салбарын хяналтын газрын Зөрчил шалган шийдвэрлэх ажиллагаа, Эрсдэлийн удирдлага хариуцсан мэргэжилтнүүдийн албан тушаалын тодорхойлолтыг тус тус боловсруулж яамны дэргэдэх Төрийн албаны салбар зөвлөлд хүргүүлж, танилцуулав.			√	
57.	Төрийн захиргааны байгууллага болон аймаг, нийслэл, дүүргийн салбарын хяналт шалгалтыг хэрэгжүүлэх нэгжийн дарга нарт улсын ахлах байцаагчийн эрх олгохтой холбогдуулан НДЕГ, ХХҮЕГ-аас тус тус судалгаа гаргуулан авч, Засгийн газрын 06 дугаар тогтоолын дагуу агентлагуудын удирдлагуудад чиглэл өгөх тухай албан бичгийг хргүүлэв.			√	
58.	Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуулийн 6.6, 7.2-т зааснаар эрх бүхий албан тушаалтнаас хэрэглэх шийтгэлийн хуудас авах талаар Сангийн яамны Төрийн сангийн газарт албан бичиг хүргүүлсэн ба аймаг, нийслэлийн нэгжийн дарга нарт шийтгэлийн хуудсыг тухайн орон нутгийн санхүү, төрийн санд хүсэлт гаргаж шийдвэрлүүлэх чиглэл хүргүүлсэн.			√	
59.	“Салбарын хяналтын чиг үүргийг хэрэгжүүлэх төрийн захиргааны байгууллагын удирдах албан тушаалтнуудтай хийх уулзалт”-ыг 03 дугаарын сарын 16-ны өдөр зохион байгууллаа. Уулзалтад танхимаар 35, цахимаар 73, нийт 108 удирдах ажилтан тус тус оролцлоо. Уулзалтаар “Салбарын бодлого, төлөвлөгөө, хөдөлмөр, эрүүл ахуй, нийгмийн хамгаалал, зөрчил шалган шийдвэрлэх ажиллагаа, эрсдэлийн удирдлага”, “Төрийн захиргааны хяналт, шалгалтыг явуулахад удирдах албан тушаалтны анхаарах асуудал”, “Хөдөлмөрийн хяналтын улсын (ахлах) байцаагчдын чиг үүрэг”, “Хөдөлмөрийн эрүүл ахуйн хяналтын улсын (ахлах) байцаагчдын чиг үүрэг”, “Нийгмийн хамгааллын хяналтын улсын (ахлах) байцаагчдын чиг үүрэг”, “Зөрчлийн хэрэг бүртгэлтийн ажиллагаанд удирдах албан тушаалтнаас тавих хяналтын чиг үүрэг, түүнийг хэрэгжүүлэх арга зам”, “Хяналтын шинэчлэл, эрсдэлд суурилсан хяналт шалгалт” сэдвээр тус тус мэдээлэл хийж, одоо тулгарч байгаа асуудал, цаашид хэрэгжүүлэх ажлын талаар санал бодлоо солилцов.			√	
60.	Хөгжлийн бэрхшээлтэй хүний хөгжлийн ерөнхий газраас зохион байгуулсан Хөдөлмөрийн тухай хуулийн 144 дүгээр зүйлийн хэрэгжилтэд зөвлөн туслах үйлчилгээ үзүүлсэн байгууллагуудын тайлангийн үр дүнгийн уулзалтад ХХҮЕГ, нийслэл, дүүргийн хөдөлмөрийн хяналтын 40 орчим улсын (ахлах) байцаагчдыг оролцууллаа.			√	
61.	Стандарт, хэмжил зүйн газраас ирүүлсэн “Бүтээгдэхүүнээс дээж авах, дээжийн хэмжээ, түүнийг хадгалах, тээвэрлэхтэй холбогдсон журам”-ын төсөлд 2023 оны 03 дугаар сарын 23-ны өдрийн 13/759 тоот албан бичгээр санал боловсруулж хүргүүлэв.			√	
62.	Уул уурхай, хүнд үйлдвэрийн яамнаас зохион байгуулсан “Хүдрийн далд уурхайн аюулгүй ажиллагааны дүрэм”-ийг боловсронгуй болгох хэлэлцүүлэгт оролцон, шинэчилсэн дүрмийн төсөлд 5 санал өгөв.			√	
63.	Хөдөлмөрийн нөхцөл, аюулгүй ажиллагааны стандартчиллын техникийн хороо (ТХ 08)-ны хуралд оролцож, дахин хянасан болон шинээр боловсруулсан 13 стандарт хэлэлцсэнээс 8 стандартын төсөлд санал өгөв.			√	
64.	Стандарт, хэмжил зүйн газрын Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн стандартын техникийн хорооны хуралд оролцож, хөдөлмөрийн эрүүл ахуйн 8 стандарт, Хөдөлмөрийн эрүүл мэнд, аюулгүй байдлын менежмент-Ажлын байран дахь сэтгэлзүйн эрүүл мэнд, аюулгүй байдал-Нийгмийн сэтгэлзүйн эрсдэлийг удирдах-Удирдамж MNS ISO 45003:2023 стандартыг хэлэлцэж, батлав.			√	

65.	Хүн ам ба хөгжил олон улсын үйл ажиллагааны хөтөлбөр /1994/, Ази, Номхон далайн бүс нутгийн Сайд нарын Хүн ам ба хөгжлийн асуудлаарх 2013 оны тунхаглалын хэрэгжилтийн үндэсний судалгааны тайлан боловсруулж байна. Энэ хүрээнд НҮБ-ын Ази, Номхон далайн бүс нутгийн Нийгмийн комиссоос ирүүлсэн судалгааны асуулгыг монгол хэлрүү хөрвүүлж, холбогдох яам, агентлагаас санал авч, боловсруулах ажлыг гүйцэтгэж байна.			√	
66.	-АХБ-тай “Монгол Улсад ахмад настны тусламж үйлчилгээний тогтолцоог хөгжүүлэх”, “Урт хугацааны тусламж үйлчилгээний чадавх бэхжүүлэх”, “Ахмад настанд ээлтэй технологийн хүртээмжийг сайжруулах” төслүүдийг 2024-2026 онд хэрэгжүүлэхээр харилцан ойлголцлын Санамж бичиг байгуулав. -АХБ-ны санхүүжилтээр хэрэгүүлж буй “Олон нийтийн оролцоонд түшиглэсэн урт хугацааны тусламж үйлчилгээний шинэлэг тогтолцоог бэхжүүлэх нь төсөл”-ийн хүрээнд СХД-ийн ЗДТГ-тай хамтран тухайн орон нутагт үйл ажиллагаа явуулж буй боловсрол, эрүүл мэнд, халамж хамгааллын үйлчилгээний болон сайн дурын байгууллагууд, өрхийн эрүүл мэндийн төв, идэвхтэй насжилтыг дэмжих төв /ИНДТ/ хамтран иргэд, тэр дундаа ахмадуудад чиглэсэн үйлчилгээ, дэмжлэг, хөрөнгө, нөөц боломж, давуу талуудаа илрүүлэх, тодорхойлох, эдгээрийг ИНДТ-ийн үйл ажиллагаатай уялдуулах боломжийн талаар хэлэлцүүлэг зохион байгуулав.			√	
67.	НҮБ-ын Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн эрхийн тухай конвенцын хэрэгжилтийн II, III тайлан илтгэлийг 2023 оны III улиралд хамгаалах бөгөөд энэ хүрээнд 2020 оноос хойш хэрэгжүүлсэн үйл ажиллагааны мэдээллийг ирүүлэх тухай дотоод албан бичгийг 2023 оны 03 дугаар сарын 17-ны өдөр газруудад хүргүүлэв.			√	
68.	“Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдэд хөгжлийн цогц дэмжлэг аргачлал, маягт шинэчлэн батлах тухай” хамтарсан тушаалын хэрэгжилтийг сайжруулах, үнэлгээ, дүгнэлт гаргах, шинэчлэн боловсруулах чиг үүрэг бүхий ажлын хэсгийг байгуулах тухай ХНХ-ын сайд, БШУ-ны сайд, ЭМ-ийн сайдын хамтарсан тушаалыг батлуулсан.			√	
69.	-ХНХЯ-ны дэргэдэх хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийг хангах дэд зөвлөлийн хурлыг 2023 оны 03 дугаар сарын 13-ны өдөр зохион байгуулсан. Хурлаар 2022 оны үйл ажиллагааны тайланг дүгнэж, 2023 оны үйл ажиллагааны төлөвлөгөөний төслийг гишүүдэд танилцуулж санал авсан. Энэ хүрээнд төлөвлөгөөний төсөлд гишүүдээс ирсэн саналыг тусган төлөвлөгөөний төслийг эцэслэн боловсруулж батлуулахад бэлтгэв. -ХНХЯ-ны дэргэдэх хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийг хангах дэд зөвлөлийн бүрэлдэхүүнийг шинэчлэх тушаалын төсөл боловсруулсан.			√	
70.	АХБ-ны “Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн оролцоог хангаж, үйлчилгээг сайжруулах төсөл”-ийн хүрээнд боловсруулагдсан “Монгол Улсын туслах технологийн үндэсний стратеги”-ийн баримт бичгийг батлуулах сайдын тушаалын төсөл бэлтгэсэн.			√	
71.	-Сэтгэцийн эрүүл мэндийн цогц арга хэмжээний төлөвлөгөөний төсөлд холбогдох саналыг ЭМЯ-нд хүргүүлсэн. -Уур амьсгалын өөрчлөлтөд дасан зохицох төлөвлөлтийн процессыг боловсронгуй болгох, үндэсний чадавхийг бэхжүүлэх төслийн хүрээнд боловсруулж буй Монгол Улсын дасан зохицох үйл ажиллагааны нэгдсэн төлөвлөгөөний төсөл холбогдох саналыг хүргүүлсэн. -“Тогтвортой хот ба олон нийтийн хамтын үйл ажиллагаа”-ны стандартын төсөлд хөгжлийн бэрхшээлийн чиглэлээр нийтлэг хэрэглэгддэг нэр томъёог тусгах чиглэлээр санал боловсруулж хүргүүлсэн. -“Хүүхдийн зуслангийн үйл ажиллагаа, ерөнхий шаардлага”-ын стандартын төсөлд хөгжлийн бэрхшээлтэй хүүхдэд ээлтэй орчин нөхцөл бүрдүүлэх, тэднийг тэгш хамруулан хөгжүүлэх чиглэлээр санал боловсруулж хүргүүлсэн. -Бүгд Найрамдах Социалист Вьетнам улсын Хөдөлмөр, хөгжлийн бэрхшээл болон нийгмийн хэргийн яамтай байгуулах хамтын ажиллагааны санамж бичгийн төсөлд санал боловсруулж хүргүүлсэн.			√	
72.	Засгийн газрын 2015 оны 269 дугаар тогтоолоор баталсан “Үйдвэрлэлийн осол, хурц хордлогыг судлан бүртгэх дүрэм”-ийн төслийг шинэчлэн боловсруулж, ажлын хэсгийн хуралд танилцуулсан. Мөн уг төсөлд санал авахаар ХНХЯ-ны цахим хуудсанд байршуулав.			√	



73.	Монгол Улсын Ерөнхий сайдын 2022 оны 10 дугаар сарын 7-ны өдрийн 159 дүгээр захирамжийг хэрэгжүүлэх хүрээнд хөдөлмөр, нийгмийн хамгааллын салбарын стандартчиллын талаарх мэдээллийг /PPT/ нэгтгэн боловсруулж, Шадар сайдын ажлын албанд хүргүүлэв.		√		
74.	Эрүүл мэндийн сайдын “Журам, жагсаалт батлах тухай” 2014 оны 340 дүгээр тушаалаар баталсан “Эрүүл мэндийн урьдчилсан болон хугацаат үзлэгийн журам”, “Хөдөлмөрийн нөхцөлөөс хамааран эрүүл мэндийн үзлэг хийх жагсаалт”-ыг шинэчлэх ажлын хүрээнд НДЕГ, ХХҮЕГ, ХАБЭМТ-д санал авахаар албан тоот хүргүүлэв. Саналыг нэгтгэн Эрүүл мэндийн яаманд хүргүүлэх юм.			√	
<b>III</b>	<b>Бодлогын хэрэгжилтийг зохицуулах чиглэлээр</b>				
75.	Хөдөлмөрийн зах зээлийн үндсэн үзүүлэлтүүдийн тоон мэдээллийг нэгтгэн 2023 оны 2 дугаар сарын байдлаар гаргаж, www.mlsr.gov.mn сайтад байршуулсан.			√	
76.	Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангийн өөрийн эх үүсвэрээс /20.0 тэрбум төгрөг/ бага хүүтэй, жижиг зээлийг олгож байгаа бөгөөд хүн амын төвлөрлийг бууруулах, орон нутагт ажлын байр бий болгох, хадгалахыг дэмжих бодлогын хүрээнд аймгуудад жилийн 4.4 хувийн хүүтэй зээлийг Төрийн банкаар, Улаанбаатар хотод жилийн 8.5-8.8 хувийн хүүтэй жижиг зээлийг Хаан банк, Төрийн банк, Худалдаа хөгжлийн банкуудаар дамжуулан олгож байна. 2023 оны 3 дугаар сарын 20-ны өдрийн байдлаар 10.8 тэрбум төгрөгийн жижиг зээлийг олгосон.			√	
77.	Монгол Улсын Ерөнхий сайдын 2023 оны 3 дугаар сарын 23-ны өдөр их, дээд сургуулийн оюутны асуудлыг сонсьё, шийдье 1000 оюутантай уулзсан уулзалтад Хөдөлмөр, нийгмийн хамгааллын дэд сайд “Оюутны цагийн ажил, хөдөлмөр эрхлэлт”-ийн талаар холбогдох танилцуулга, мэдээллийг бэлтгэн оролцов. Тус уулзалтын хүрээнд “Оюутны талаар авах зарим арга хэмжээний тухай” Засгийн газрын тогтоолын төслийг холбогдох яамдуудтай хамтран боловсруулж Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын хэрэгжүүлэх үйл ажиллагааны саналыг боловсруулан тусгаж Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлэн батлуулахаар ажиллаж байна.			√	
78.	Хөдөлмөрийн тухай хууль 2021 онд шинэчлэгдэн батлагдсантай уялдуулан хөдөлмөрийн сонирхлын маргааны 2022 оны статистик мэдээг Үндэсний статистикийн хорооны даргын 2014 оны А/158 дугаар тушаалаар батлагдсан маягтаар дүйцүүлэн гаргаж 2023 оны 03 дугаар 20-ны 02/716 тоот албан бичгээр ҮСХ-нд хүргүүлэв.			√	
79.	Монгол Улсын сайд, ЗГХЭГ-ын даргын 2023 оны 3 дугаар сарын 16-ны өдрийн 24 дүгээр тушаалаар “Төрийн албан хаагчийн цалин, ажиллах нөхцөл, нийгмийн баталгааны асуудлыг судалж санал боловсруулах” ажлын хэсгийг байгуулсан. Уг ажлын хүрээнд ЗГХЭГ-ын холбогдох албан тушаалтнуудад төрийн албан хаагчдын цалин хөлсний талаарх өнөөгийн байдал, тулгамдаж буй асуудал, цаашид хэрэгжүүлэхээр төлөвлөж буй үйл ажиллагааны талаар танилцуулав.		√		
80.	Монгол Улсын Соёлын яам, Монголын ажилтан, албан хаагчдын үйлдвэрчний эвлэлийн холбооны 2023-2024 оны салбарын хамт /тариф/-ын хэлэлцээрийг Хөдөлмөрийн тухай хуулийн 32 дугаар зүйлийн 32.2 дах хэсэгт заасны дагуу 2023 оны 3 дугаар сарын 16-ны өдөр хянан бүртгэж авсан.			√	
81.	ХНХЯ-ны цахим шилжилтийн үйл ажиллагаа, цаашид хэрэгжүүлэх арга хэмжээний талаар мэдээлэл танилцуулгыг бэлтгэн Төрийн ордны “Их Засаг” танхимд 2023 оны 03 дугаар сарын 29-ний өдрийн 11:00 цагт зохион байгуулав.			√	
82.	ХНХЯ-ны Төрийн нарийн бичгийн даргын 2023 оны А/67 дугаар тушаалын дагуу Дорнод аймгийн Нийгмийн даатгалын хэлтсийн дэргэдэх Эмнэлэг хөдөлмөрийн магадлах комиссын үйл ажиллагаа, хөдөлмөрийн чадвар алдалтын хувь хэмжээ, хугацааг даатгуулагчид тогтоосон байдалд Нийгмийн даатгалын бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын дарга болон холбогдох мэргэжилтнүүд Дорнод аймагт 2023 оны 3 дугаар сарын 27-31-ний өдөр хяналт, шалгалт хийв.			√	
83.	Бүгд Найрамдах Сингапур Улсын Сингапурын хамтын ажиллагааны байгууллагын төлөөлөлтэй Монгол Улсын онцлогт нийцсэн Хуримтлалын нэгдсэн сан бүрдүүлэх ажлын хүрээнд ээлжит албаны уулзалтыг 2023 оны 3 дугаар сарын 17, 30-ны өдрүүдэд тус тус зохион байгуулав. Цахим уулзалтаар тус байгууллагаас ХНХЯ-нд хүлээлгэн өгөх 3 дугаар шатны үйл ажиллагааны тайлангийн агуулгыг танилцуулж, санал солилцов.			√	

84.	Олон улсын зөвлөх, актуарч Питер Томпкинстой Хувийн нэмэлт тэтгэврийн тухай хуулийн хуулийн төслийн концепц, NDC үед шилжилтийн DB:NDC холимог томъёог хэрхэн хэрэглэх, K коэффициент тооцох болон бусад асуудлаар ярилцлаа.				
85.	АНУ-ын Чикаго хотноо 2023 оны 03 дугаар сарын 21-23-ны өдрүүдэд зохион байгуулагдсан дэлхийн 6 тивийн 30 улсын 700 гаруй төлөөлөгч оролцсон “Орон гэргүй иргэдийн асуудал-2023” чуулганд Монгол Улсыг төлөөлж тус яамны Нийгмийн халамжийн бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын дарга “Монгол Улс дахь гэр оронгүй тэнэмэл амьдралтай өрх, иргэний нөхцөл байдлын” талаар илтгэл тавьж оролцлоо. Мөн чуулганд оролцож буй Вангард хөтөлбөрийг хэрэгжүүлж байгаа улс орнуудын төлөөлөлтэй уулзаж Гэр оронгүй тэнэмэл иргэдийн талаар хэрэгжүүлж байгаа арга хэмжээ, хөтөлбөр, бодлогын талаар санал солилцож, туршлага хуваалцав.			√	
86.	Байнгын асаргаа шаардлагатай иргэний тэтгэмжид хамрагдаж байгаа ч албан журмаар нийгмийн даатгалын шимтгэл төлж байгаа хөгжлийн бэрхшээлтэй иргэдийг эрүүл мэндийн байгууллагын дэргэдэх Эмнэлэг хяналтын комиссын хурлаар дахин магадлах, Амьжиргааг дэмжих зөвлөлийн хурлаар хэлэлцүүлэх, холбогдох санал боловсруулж танилцуулах талаар Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний ерөнхий газарт 2023.03.27-ны 2/778 тоот албан бичгээр чиглэл хүргүүлэв.			√	
87.	ХНХЯ-наас Азийн хөгжлийн банк /АХБ/-тай хамтран хэрэгжүүлсэн “Үр дүнтэй нийгмийн халамжийн системийн чадавхи бэхжүүлэх нь ТТ 9893-МОН” төслийн үр дүнг дүгнэх хэлэлцэх зорилгоор АХБ-ны Зүүн азийн бүсийн газрын төсөл хариуцсан нийгмийн хамгааллын тэргүүлэх мэргэжилтэн, төслийн багийн ахлагч Карин Шелцихтэй 2023 оны 3 дугаар сарын 03-ны өдөр уулзалт зохион байгууллаа. Уулзалт, хэлэлцүүлгээр “Нийгмийн халамжийн салбарын бодлого боловсруулагчид, ажилтнуудын чадавхыг бэхжүүлэх”, “Нийгмийн халамжийн бодлогын судалгаа, хэлэлцүүлэг хийх, нөлөөллийн ажлыг дэмжих”, “Олон нийтийн оролцоонд түшиглэсэн халамжийн үйлчилгээний хяналт, шалгалтын үнэлгээг бэхжүүлэх” гэсэн үндсэн 3 чиглэлээр хийгдсэн ажлууд болон 21 аймаг, 9 дүүргийн нийгмийн халамжийн байгууллагын удирдах ажилтан, хөдөлмөр, халамжийн асуудал хариуцсан мэргэжилтэн, дүүргийн Амьжиргаа дэмжих зөвлөлийн гишүүдийг хамруулан 7 удаагийн нийт 2000 гаруй оролцогчтой сургалтыг цахим болон танхим хосолсон сургалтын үр дүнг үнэлэн цаашид хамтран ажиллах төслийн саналуудыг хэлэлцэв.			√	
88.	Нийслэлийн Прокурорын газар, нийслэлийн Хөдөлмөр, халамжийн газрын хамтарсан “Зөрчил шалган шийдвэрлэх ажиллагааг Зөрчлийн тухай, Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуульд нийцүүлэн явуулах талаарх мэдлэг олгох” сургалтад Нийслэлийн хөдөлмөр, халамжийн газар болон дүүргүүдийн хөдөлмөр, халамжийн үйлчилгээний хэлтсийн 40 гаруй удирдах албан тушаалтан оролцлоо.			√	
89.	Харьяа агентлаг, аймаг, нийслэл, дүүрэг дэх салбарын хяналт шалгалтыг хэрэгжүүлэх байгууллагын улсын (ахлах) байцаагч нарт Монгол Улсын Шадар сайд, Байнгын ажиллагаатай зөвлөлийн даргын 2017 оны 08 дугаар тушаалын 1 дүгээр хавсралтаар батлагдсан “Болзошгүй гамшиг, нийгмийн эрүүл мэндийн ноцтой байдлын үеийн салбар хоорондын мэдээлэл солилцох, хариу арга хэмжээг шуурхай зохион байгуулах журам”-ын холбогдох заалтуудыг үндэслэн барилга, уул уурхай болон бусад салбаруудад хүний эрүүл мэнд, амь нас хохирсон, үйлдвэрлэлийн осол, хурц хордлого, үйлдвэрийн ажилтны хоолны газарт хоол, хүнсээр дамжих өвчин гарсан аж ахуйн нэгж, байгууллагын үйлдвэрлэлийн талбай, ажлын байранд шуурхай дуудлагаар ажиллахдаа хөдөлмөрийн аюулгүй ажиллагаа, эрүүл ахуйн шаардлагыг хангах, бүх шатны удирдах албан тушаалтнуудыг эх сурвалжаас цаг алдалгүй, үнэн зөв, шуурхай мэдээ, мэдээллээр хангах, солилцох, дамжуулах, шаардлагатай арга хэмжээ авах үйл ажиллагааг зохицуулах талаар чиглэл хүргүүлэв.			√	
90.	2023 оны хяналт шалгалтын төлөвлөгөөний төсөлд нийт 2413 объект төлөвлөгдснөөс 1337 объект хөдөлмөрийн хяналтын чиглэлээр, 410 объект хөдөлмөрийн эрүүл ахуйн хяналтын чиглэлээр, 666 объект нийгмийн хамгааллын хяналтын чиглэлээр сонгож хяналт шалгалт хийхээр байна.			√	
91.	Засгийн газрын 269 дүгээр тогтоол “Үйлдвэрлэлийн осол, хурц хордлогыг судлан бүртгэх дүрэм”-ийг шинэчлэн боловсруулах ажлын хэсэгт ажиллаж, ажлын хэсгийн хурлаар шинэчилсэн дүрмийг хэлэлцүүлж, санал солилцсон.			√	

92.	Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдэд хөгжлийн цогц дэмжлэг үзүүлэх салбар дундын хэлэлцүүлгийг сар бүр зохион байгуулдаг болсон бөгөөд дараагийн уулзалтыг манай яам хариуцан зохион байгуулна. Энэ хүрээнд хөдөлмөр, нийгмийн хамгааллын салбарт хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн асуудлаар хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөөг боловсруулж, ХНХ-ын дэд сайдаар батлуулав.			√	
93.	-ЭМЯ-наас зохион байгуулсан “Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдэд хөгжлийн цогц дэмжлэг үзүүлэх салбар дундын уулзалт хэлэлцүүлэг”-ийн хүрээнд салбарт хэрэгжүүлсэн үйл ажиллагааны талаар мэдээллийг боловсруулж, танилцуулав. -Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийг хангах зөвлөлийн 2023 оны үйл ажиллагааны төлөвлөгөөний I улирлын хэрэгжилтийн тайланг дэд болон салбар зөвлөлүүдээс авч, нэгтгэв.			√	
94.	-ЖАЙКА байгууллагатай хамтран хэрэгжүүлж буй “Монгол Улс дах хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн хөдөлмөр эрхлэлтийн тогтолцоог бэхжүүлэх төсөл”-ийн хүрээнд “Ажлын байрны дадлагажуулагч бэлтгэх анхдугаар сургалт”-ыг 2023 оны 03 дугаар сарын 27-30-ны өдрүүдэд зохион байгуулав.			√	
95.	“Хөгжлийн бэрхшээл ба тэгш байдлын тухай сургалт”-ыг төрийн болон хувийн хэвшлийн 300 гаруй хүнд зохион байгууллаа.			√	
96.	Салбарын хяналтын хуудас боловсруулагдаж байгаатай холбоотой яамдруу салбарын хяналтын хуудаст хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн асуудлыг тусгах тухай албан бичгийг төлөвлөж, салбар бүрт хамаарах асуудлын жагсаалтыг боловсруулж яамдад хүргүүлсэн.			√	
97.	Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын 2019 оны А/370 дугаар тушаалаар баталсан "Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн сургалт явуулах болон шалгалт авах журам"-ыг шинэчлэн боловсруулах ажлын хэсэг шинэчлэн байгуулах тухай тушаалыг 2023 оны 03 дугаар сарын 01-ний өдөр Төрийн нарийн бичгийн даргын А/43 дугаар тушаалаар баталж, ажлын хэсгийн 2 дахь удаагийн хурлыг 03 дугаар сарын 01-ний өдөр зохион байгуулав.			√	
98.	Хөдөлмөрийн сайдын 2015 оны А/223 дугаар тушаалаар баталсан “Ажлын байрны хөдөлмөрийн нөхцөлийн үнэлгээ хийх журам”-ыг шинэчлэн боловсруулах ажлын хэсгийн бүрэлдэхүүнийг Төрийн нарийн бичгийн даргын 2023 оны 03 дугаар сарын 01-ний өдрийн А/42 дугаар тушаалаар баталж, ажлын хэсгийн эхний хурлыг 03 дугаар сарын 01-ний өдөр зохион байгууллаа.			√	
99.	Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн үндэсний хороо болон тус яамны Хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газраас өгсөн хугацаатай үүрэг даалгавар, зөвлөмжийн дагуу авч хэрэгжүүлсэн арга хэмжээний тайланг Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл мэндийн төвөөс албан тоотоор авч боловсруулан дэд сайдад танилцуулав.			√	
100.	Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын 2019 оны А/64 дүгээр тушаалаар баталсан журмын дагуу “Эрүүл аюулгүй ажлын байрыг эрхэмлэгч байгууллага - 2022” шалгаруулах уралдааны 2 дахь шатны шалгаруулалтын ажлын хэсэгт ажиллаж байна.			√	
101.	Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн салбар хорооны бүтэц, зохион байгуулалт, үйл ажиллагаа, туршлагын талаарх түүхэн ном боловсруулах ажлын хүрээнд ажлын төлөвлөгөө боловсруулан батлуулав.			√	
102.	Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн сарын аяныг зохион байгуулах ажлын төлөвлөгөөнд МАОЭНХ, МҮЭХ, ХАБЭМТ-өөс санал авч нэгтгэн боловсруулж, батлуулав.			√	